



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/177

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.17, 19.2.4 дэх заалт, "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоол, "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 275 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 276 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаадын иргэн, харьяатын газрын зохион байгуулалтын бүтэц"-ийг нэгдүгээр хавсралтаар, "Гадаадын иргэн, харьяатын газрын зохион байгуулалтын нэгжийн орон тоо, албан тушаалын зэрэглэл"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/20 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийн 3.3.1-3.3.9 дахь заалтын "дэд дарга" гэснийг хассугай.

3. Энэ тушаалд нийцүүлэн Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь нэгжийн орон тоо, албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг батлагдсан орон тооны хязгаарт багтаан шинэчлэн баталж, мөрдүүлэхийг Гадаадын иргэн, харьяатын газрын дарга /Н.Ууганбаяр/-д даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/20 дугаар тушаалын хоёр, гуравдугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.




Х.НЯМБААТАР

151600630




Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн
А/177 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн
А/177 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
НЭГЖИЙН ОРОН ТОО, АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын зэрэглэл
Удирдлага-1			
1	Дарга	1	T3-14
Захиргаа, удирдлагын газар-20			
1	Газрын дарга	1	T3-11
2	Ахлах мэргэжилтэн	7	T3-7
3	Мэргэжилтэн	8	T3-6
4	Ахлах архивч-операторч	1	TY-8
5	Сан хөмрөгийн эрхлэгч	1	TY-6
6	Бичиг хэргийн эрхлэгч	1	TY-5
7	Бичээч	1	TY-2
Виз, зөвшөөрлийн газар-29			
1	Газрын дарга	1	T3-11
2	Ахлах мэргэжилтэн	9	T3-7
3	Мэргэжилтэн	19	T3-6
Иргэний харьяаллын газар -7			
1	Газрын дарга	1	T3-11
2	Ахлах мэргэжилтэн	1	T3-7
3	Мэргэжилтэн	5	T3-6
Зөрчил шалган шийдвэрлэх газар-21			
1	Газрын дарга, хяналтын улсын ахлах байцаагч	1	T3-11
2	Хяналтын улсын ахлах байцаагч	4	T3-8
3	Хяналтын улсын байцаагч	15	T3-7
4	Мэргэжилтэн	1	T3-6
Санхүүгийн хэлтэс-8			
1	Хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч	1	T3-10
2	Ахлах мэргэжилтэн	2	T3-7
3	Ахлах нягтлан бодогч	3	TY-8
4	Нярав	2	TY-4
Хангалт, үйлчилгээний хэлтэс-21			
1	Хэлтсийн дарга	1	T3-10
2	Аж ахуйн менежер	1	TY-7
3	Их эмч	1	TY-6
4	Биеийн тамирын арга зүйч	1	TY-6
5	Автомеханикч-жолооч	1	TY-5
6	Жолооч	6	TY-3

7	Сантехникч	2	ТҮ-3
8	Цахилгаанчин	1	ТҮ-3
9	Мужаан	1	ТҮ-2
10	Үйлчлэгч	6	ТҮ-1
Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс-5			
1	Хэлтсийн дарга	1	ТЗ-10
2	Ахлах мэргэжилтэн	1	ТЗ-7
3	Мэргэжилтэн	3	ТЗ-6
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс-6			
1	Хэлтсийн дарга	1	ТЗ-10
2	Ахлах мэргэжилтэн	3	ТЗ-7
3	Мэргэжилтэн	2	ТЗ-6
Мэдээллийн технологийн хэлтэс-12			
1	Хэлтсийн дарга	1	ТЗ-10
2	Ерөнхий инженер	1	ТҮ-8
3	Ахлах мэргэжилтэн	1	ТҮ-8
4	Өгөгдлийн сангийн инженер	1	ТҮ-7
5	Программ хангамжийн инженер	3	ТҮ-7
6	Сүлжээний инженер	3	ТҮ-7
7	Хэвлэлийн эх бэлтгэгч	2	ТҮ-6
НИЙТ		130	

---oOo---